

Сүрьеэ өвчний цээжний рентген шинжилгээ (ТВ)

Chest x-ray monitoring for tuberculosis (TB)

Mongolian

Цээжний рентген шинжилгээ гэж юу вэ, би яагаад уг шинжилгээнд хамрагдах хэрэгтэй вэ?

Таны эмч таны сүрьеэ (ТВ) өвчнийг хянахын тулд цээжний рентген шинжилгээнд тогтмол хамруулахыг хүсч магад юм. Рентген зураг нь таны уушгинд гарсан аливаа өөрчлөлтийг хянахад тусална.

Цээжний рентген зургаар дараах зүйлсийг тодорхойлох боломжтой байдаг:

- сүрьеэгийн халдвар (ТВ) сүрьеэгийн өвчин (ТВ) болж өөрчлөгдсөн эсэхийг харах.
- Сүрьеэгийн өвчин (ТВ) нь эм ууснаар сайжирч байгаа эсэхийг шалгах.

Рентген туяа нь хортой юу?

Рентген туяа нь бага хэмжээний цацраг хэрэглэдэг. Уг цацрагийн хэмжээ нь урт хугацаагаар онгоцоор нисэх үед өртдөг цацрагийн хэмжээтэй адил хэмжээтэй байдаг. Рентген шинжилгээ олон удаа хийлгэсэн ч ийм хэмжээний цацрагийг аюулгүй гэж үздэг.

Хэрэв та жирэмсэн байх боломжтой бол рентген зураг авахаас өмнө энэ талаар эмчдээ мэдэгдэх нь чухал. Рентген зургийг хойшлуулан төрсний дараа хийлгэх боломжтой эсэхийг эмч тантай ярилцах болно. Жирэмсэн байх үедээ рентген зураг авахуулах шаардлагатай бол танаас ургийг хамгаалах зорилгоор зураг авах үед тусгай хар тугалгатай хормогч зүүхийг хүсэх болно.

Хөхүүл эхчүүд нярай хүүхдээ хөхний сүүгээрээ хооллоход аюулгүй.

Цээжний рентген зураг авахуулсны дараа юу болох вэ?

Рентген зургийн мэргэжилтэн таны рентген зургийг авах болно. Зураг авахын өмнө эмч таныг үнэт эдлэлээ тайлах эсвэл өвчтөний нэг удаагийн даахинз өмсөхийг хүсч магадгүй. Хэрэв та өрөөнд туслах хүнтэй байхыг хүсвэл уг ажилтнаас асуугаарай.

Рентген зураг авахад хэдхэн секунд л хангалттай. Рентген зураг авах үед танаас гүнзгий амьсгал авч хөдөлгөөнгүй байхыг хүсэх болно.

Хэрэв та сүрьеэгийн эмнэлэг (ТВ), эсвэл цээжний эмнэлэгт үзүүлж байгаа бол хамгийн сүүлд хэзээ, хаана цээжний рентген зураг авхуулсан тухайгаа мэдэгдээрэй.

Рентген зургийг эмч рүү илгээдэг. Эмч уг зургийг өмнөх цээжний рентген зурагтай харьцуулан таны уушгинд гарсан өөрчлөлтийг гарсан эсэхийг тодорхойлно. Үүнд тодорхой хугацаа шаардагдаж магадгүй. Таны уушгинд ямар нэгэн өөрчлөлт илэрч, дахин эмчид үзүүлэх шаардлагатай бол эмнэлэг тантай холбогдох болно.

Би хэр удаан цээжний рентген шинжилгээний хяналтанд хамрагдах шаардлагатай вэ?

Ихэнх хүмүүс 6-12 сар тутамд цээжний рентген зураг авахуулах шаардлагатай байдаг. Хэрэв 2-3 жилийн хугацаанд таны рентген зурагт ямар нэгэн өөрчлөлт гарахгүй бол эмч цаашид цээжний рентген шинжилгээ хийх шаардлагагүй гэж үзэж болно. Хэрэв танд санаа зовж буй асуудал байгаа бол эмчтэйгээ ярилцана уу.

Нэмэлт мэдээлэл

Сүрьеэ (TB) өвчний талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл health.nsw.gov.au/tb цахим хаягаар зочилно уу.

Өөрийн хэлээр үнэ төлбөргүй туслалцаа авахыг хүсвэл Орчуулгын Үйлчилгээ (TIS)-ний 13 14 50 дугаарт залгана уу.